



**ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
(2023 оны эхний хагас жилийн байдаар)**

2023 он

**ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН
ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
(2023 оны эхний хагас жилийн байдаар)**

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Эрүүл мэндийн яамны харьяа агентлаг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн хэрэгжилтэд 2023 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хүрсэн түвшинг тогтоон, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулах, удирдлагыг бодит мэдээлэл, санал зөвлөмжөөр хангахад оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн хэрэгжилтийг үнэлэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам батлах тухай” 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай 374 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам батлах тухай” А/346 дугаар тушаалыг үндэслэн гүйцэтгэлээ. Үнэлгээг харьяа агентлаг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд, аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвөөс ирүүлсэн чанарын үзүүлэлтийн тайлан болон Эрүүл мэндийн хөгжлийн төвийн статистикийн сарын мэдээ, тайланг үндэслэн гүйцэтгэсэн болно.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

3.1 Харьяа байгууллагуудын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3 дугаар хавсралтын 3.8-д тусгагдсан “Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг,

тусгай мэргэжлийн төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт"-ийн дагуу үндсэн шалгуур үзүүлэлт болон байгууллага тус бүрийн өвөрмөц үзүүлэлтийг харгалзан үнэлсэн болно.

Үнэлгээгээр харьяа байгууллагуудын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний дундаж хувь 78.6% буюу "тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэгдлээ.

- ❖ Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтээс харахад улсын хэмжээний үйлчилгээтэй 12 төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн хоног болоогүй нас баралт /8-24 цагийн дотор/ 23.8 хувь буюу өнгөрсөн оны мөн үеэс 0.1 хувиар буурсан боловч УНТЭ, ХӨСҮТ, ХСҮТ, СЭМҮТ, ЭНЭҮТ-II, Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад нэмэгдсэн бол УГТЭ, ГССҮТ-д буурсан үзүүлэлтэй байна.
- ❖ 2022 онд харьяа төрөлжсөн мэргэшлийн 13 эмнэлгүүдэд задлан шинжилгээний хамралтын хувь 59.2%-тай байгаа нь "Эмгэг судлалын шинжилгээ хийх журмыг шинэчлэн батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/55 тушаалын хэрэгжилт хангалтгүй байна.
- ❖ Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт болох үндсэн оношийн зөрүү 2023 оны эхний хагас жилд бодит тоогоор ГССҮТ-1, УГТЭ-1, ХӨСҮТ-1, ЭХЭМҮТ-13, ЭНЭҮТ-8, Хүрээ амаржих газар-1, Амгалан амаржих газар-2, Өргөө-2 буюу нийт 29 бүртгэгдсэн нь нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн нийт үндсэн оношийн зөрүүний 48.2%-г эзэлж байна.
- ❖ Харин давтан хагалгаа хийгдсэн үзүүлэлт өмнөх оны мөн үеэс Ховд аймаг дахь БОЭТ-д буурсан бол Орхон, Өвөрхангай аймгууд дахь БОЭТ-д өссөн, Дорнод, Өмнөговь аймгууд дахь БОЭТ-д бүртгэгдээгүй байна. Мэс заслын дараах хүндрэлийн үзүүлэлт УНТЭ, ХӨСҮТ, Орхон, Өвөрхангай аймгууд дахь БОЭТ-д өмнөх оны мөн үеэс тус тус нэмэгдсэн үзүүлэлтэй байгаа зэргээс үзэхэд цаашид эмч мэргэжилтнүүдийн бэлэн мэдлэг, ур чадвар, дадлыг сайжруулах талаар эмнэлгүүд тодорхой үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага зохион байгуулалтыг улам сайжруулах шаардлагатайг харуулж байна.
- ❖ Үндэсний лавлагаа төвүүд нь улсын хэмжээний мэдээ мэдээлэл, тоо баримтыг нэгтгэн төвлөрүүлэх, тохиолдолд суурилсан хэлэлцүүлэг, хурлаас гарсан зөвлөгөө зөвлөмжийг бусад эрүүл мэндийн байгууллагуудад нэгдсэн журмаар хүргүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах асуудал хангалтгүй байсаар байна.

3.2 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газруудын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3 дугаар хавсралтын 3.8-д тусгагдсан “Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээг гүйцэтгэсэн. Үнэлгээгээр аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын тусламж үйлчилгээний чанарын дундаж хувь 78.1% буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдлээ.

- ❖ Артерын даралт ихсэх өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 18 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь аймгийн дунджаар 24.3 ба Архангай, Баян-Өлгий, Завхан, Ховд, Хөвсгөл зэрэг аймгууд аймгийн дунджаас доогуур, Баянхонгор, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Увс аймгууд аймгийн дунджаас дээгүүр байна.
- ❖ Өрх, сумын эрүүл мэндийн төвийн нийт үзлэгт гэрийн эргэлтийн эзлэх хувь аймгийн дунджаар 12,8 ба Дундговь, Төв, Сүхбаатар, Хэнтий, Хөвсгөл аймгуудад 5-6.9% байгаа нь хангалтгүй, бусад аймгууд болон нийслэлд гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээний хувь хангалттай байна.
- ❖ Улсын хэмжээнд дэх товлотт дархлаажуулалтын хувь Дундговь, Дорноговь аймгаас бусад аймаг болон нийслэлд 90 хувиас дээш үзүүлэлттэй байна.
- ❖ Жирэмсний эхний 3 сард хяналтанд орсон эхийн эзлэх хувь улсын хэмжээнд 88 хувиас дээш байгаа боловч Дорноговь аймаг болон Улаанбаатар хотод эхийн эндэгдлийн нийт 7 тохиолдол гарсан сөрөг үзүүлэлттэй байна.
- ❖ 15-49 насны эмэгтэйчүүдийн дундах үр хөндөлтийн түвшин Архангай, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Орхон, Өмнөговь, Увс аймаг, нийслэл Улаанбаатар хотод улсын дунджаас дээгүүр, Өсвөр насны 1000 эмэгтэйд ноогдох үр хөндөлтийн түвшнээр Баянхонгор, Дорнод, Өмнөговь аймгуудад улсын дунджаас дээгүүр байна.
- ❖ Нялхасын эндэгдлийн түвшин аймгийн дунджаар 11.4 байгаа ба Баян-Өлгий, Баянхонгор, Завхан, Өвөрхангай, Ховд, Хөвсгөл аймагт аймгийн дунджаас дээгүүр, 5 хүртэлх насны хүүдийн эндэгдлийн түвшин аймгийн дунджаар 14.4 байгаа ба Баян-Өлгий, Дархан-уул, Орхон, Өвөрхангай, Ховд, Хөвсгөл аймагт аймгийн дунджаас дээгүүр байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Эрүүл мэндийн яамны харьяа агентлаг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дунджаар тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт 78.6%-ийн гүйцэтгэлтэй; аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газруудын дундаж 78.1%-ийн гүйцэтгэлтэй; Салбарын хэмжээнд 2023 оны хагас жилийн гүйцэтгэл 78.3% буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдэв.

(ЭМХТ-ийн 2023 оны хагас жилийн гүйцэтгэл 75.7% байна)

- ❖ Харьяа байгууллагуудын тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлттэй холбоотой дараах нийтлэг асуудлууд байна. Үүнд:
 - хоног болоогүй нас баралтын эмнэлгүүдийн дундаж нь сүүлийн 2 жилд ижил түвшинд байгаа нь эмнэлгүүд нарийвчилсан дүн шинжилгээ хийж, яаралтай тусламжийн үйлчилгээний чанарыг сайжруулах шаардлагатайг харуулж байна
 - задлан шинжилгээний хамралтын хувь хангалтгүй байна
 - Эмнэлгийн статистик мэдээллийн албанаас мэдээ тайланг үнэн зөв гаргах, ЭМТҮЧБА-аас эмнэлэгт бүртгэгдсэн өвчлөл, нас баралт, давтан хагалгаа, хагалгааны хүндрэл, түүнд нөлөөлсөн шалтгааныг судалж дүн шинжилгээ хийж ажилласан байдал хангалтгүй байна
 - ЭМДЕГ нь эрүүл мэндийн байгууллагатай байгуулсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээнд тусгагдснаар төлбөрийн нэхэмжлэлийн хяналтын тайлан, эрүүл мэндийн байгууллага дээр хийх хяналт, гэрээний хэрэгжилтийг хянасан тухай дүгнэлт, эмнэлзүйн аудит хийсэн шинжээчийн дүгнэлт тус бүрийг хяналт дууссанаас хойш ажлын 5 хоногт багтаан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид хариу хүргүүлж хэвшээгүй байна.
- ❖ Эрүүл мэндийн газруудын тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлттэй холбоотой дараах нийтлэг асуудлууд байна. Үүнд:
 - Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоонд улсын хэмжээнд 0-17 насны 620256 хүн хамрагдсан ба энэ нь хамрагдвал зохих хүн амын 50%; 18-с дээш насны 431592 хүн хамрагдсан нь хамрагдвал зохих хүн амын 20.3%-ийг эзэлж байна. Улсын хэмжээнд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоонд хамрагдалт 35.1% байна.
 - Жирэмсний эхний 3 сард хяналтанд орсон эхийн эзлэх хувь улсын хэмжээнд 88 хувиас дээш байгаа боловч Дорноговь аймаг болон Улаанбаатар хотод эхийн эндэгдлийн нийт 7 тохиолдол бүртгэгдэж, 100000 амьд төрөлтөд 25.3

ногдож байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеээс 3 тохиолдлоор буюу 100000 амьд төрөлтөд 15.0-аар багассан харагдаж байгаа ч КОВИД-ын өмнөх үе буюу 2019 оны мөн үеийн түвшинд хэвээр байна.

- Тайлант хугацаанд нялхсын эндэгдлийн нийт 350 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 12.7 ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 28 тохиолдлоор буюу 0.3-аар өссөн үзүүлэлттэй байгаа ч КОВИД-ын өмнөх үетэй харьцуулахад 0.9-өөр буурсан байна.
- Тайлант хугацаанд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 413 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 14.9 ногдож байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 тохиолдлоор өссөн үзүүлэлттэй байгаа ч КОВИД-ын өмнөх үетэй харьцуулахад 1.6-аар буурсан байна.
- Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Дархан-уул, Дорнод, Орхон, Өвөрхангай, Увс, Ховд, Хөвсгөл зэрэг 10 аймагт амьгүй төрөлтийн түвшин аймгийн дунджаас дээгүүр байгаа нь жирэмсний хяналтын үйл ажиллагааг чанаржуулах шаардлагатай байгааг харуулж байна.
- Архангай, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Орхон, Өмнөговь, Увс зэрэг 7 аймагт 1000 амьд төрөлтөд ногдох үр хөндөлтийн харьцаа аймгийн дунджаас дээгүүр байгаа нь жирэмснээс сэргийлэх арга хэрэгслийг сурталчилах, өсвөр насны хүүхдэд эрүүл мэндийн боловсролыг олгох асуудалд анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна.
- 2023 оны эхний 5 сарын байдлаар осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 1064 тохиолдол бүртгэгдэж, нийт нас баралтын 15.2 хувийг эзэлж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 249 тохиолдлоор буурсан бөгөөд 10000 хүн амд ногдох осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 3.2 байна. Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтад эзлэх амиа хорлолтын хувь улсын хэмжээнд 17.4 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0.8-аар өссөн байна. Уг үзүүлэлт Архангай, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-уул, Завхан, Өвөрхангай, Ховд, Хөвсгөл аймгуудад аймгийн дунджаас дээгүүр байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

- ❖ Эмнэлэгт бүртгэгдсэн нас баралтаас зайлшгүй эмгэг судлалын шинжилгээнд хамрагддаг тохиолдол /11/-уудыг бүрэн хамруулах, эмчилгээ үйлчилгээний дутагдал, хоног болоогүй нас баралт, давтан мэс засал, мэс заслын дараах хүндрэл зэрэг үзүүлэлтүүдийн чанарыг сайжруулахад онцгой анхаарч тодорхой ажил зохион байгуулах

- ❖ Улсын хэмжээнд эхийн болон нялхсын эндэгдлийн түвшин бууруулах, жирэмсний эрт хяналт ба тогтмол хяналтын үйл ажиллагааг чанаржуулах, аливаа эмгэгийг эрт үед нь илрүүлэх, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авах, өсвөр насны хүүхдүүдэд бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх, жирэмснээс хамгаалах арга хэрэгслийг таниулах, сурталчилах, эрүүл мэндийн боловсрол олгоход чиглэсэн цогц арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх
- ❖ Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчний илрүүлэг шинжилгээ болон улсын хэмжээнд зохион байгуулж байгаа эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд 18-аас дээш насны хамрагдвал зохих иргэдийн 24% нь хамрагдаад байгаа тул иргэдийг бүрэн хамруулж, өвчлөл илэрсэн тохиолдлыг эмнэлгийн хяналтад авч хяналт тавьж ажиллах
- ❖ Үндэсний лавлагаа төвүүд нь улсын хэмжээнд эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр хангаж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт, тоон мэдээллийг нэгтгэх, дүн шинжилгээ хийж, эргэн мэдээлж ажиллах

Эрүүл мэндийн яам.
Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар